

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийтлэг үйлчилгээ Улсын төсөвт үйлдвэрийн газрын 2023 оны
санхүүгийн тайланд хийсэн хураангуй аудитын тайлан

Аудитын код: ГАА-2024/14/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
	Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
	Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор: М.Атарцэцэг
	Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn
	Аудитор: Б.Мөнхболд
	Утас: 99041008 Цахим хаяг: munkhboldbo@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.14

№

118

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Нийтлэг үйлчилгээ” УТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Нийтлэг үйлчилгээ УТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ой, Туульсын хаан “ЖАНГАР” тууль хайлах арга хэмжээ, Нарванчин гэгээнтний “БАТ ОРШИЛ” даншиг наадам, Дөргөн нуурын чуулга уулзалт, Ховд мөнгөн шагшуурга зэрэг арга хэмжээнүүдийн зохион байгуулалтад оролцсон байна. Мөн Засаг даргын Тамгын газрын 1, 3 дугаар байруудад их засвар, 2 дугаар байранд урсгал засварын ажлыг хийсэн байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 156,554.4 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдын цалин, хөлс нэмэгдсэн, мөн дээрх арга хэмжээнүүдийг зохион байгуулан оролцсонтой холбоотой байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 14,221.2 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан төв цэнгэлдэх хүрээлэнгийн барилга, зам талбай, ногоон байгууламж бүхий 7,068,920.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр орлогодож авсан байна.

0702900334

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 1 хөтөлбөр, 3 зорилт, 18 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 17 арга хэмжээг бүрэн, 1 арга хэмжээг 78 хувиар, хэрэгжүүлж, аймгийн Засаг дарга 92.6 хувиар үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	57,606,409.46	67,328,001.99
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	24,832,641.67	7,066,946,055.10
Нийт хөрөнгийн дүн	82,439,051.13	7,134,274,057.09
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	82,439,051.13	7,134,274,057.09
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	82,439,051.13	7,134,274,057.09
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	437,729,100.00	607,549,525.00
Үйл ажиллагааны зардлын дүн	394,367,668.66	624,634,888.04
Үйл ажиллагааны үр дүн	437,581,100.00	607,549,525.00
Үйл ажиллагааны бус үр дүн	26,925,800.00	7,068,920,369.00
Үйл ажиллагааны нийт үр дүн	(165,839,300.00)	7,051,835,005.96
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		82,439,051.13
Тайлант оны үр дүн	(165,839,340.41)	7,051,835,005.96
Эцсийн үлдэгдэл	(189,384,401.84)	7,134,274,057.09
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	457,295,000.00	621,303,781.00
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	450,362,200.00	607,958,996.56
Үйл ажиллагааны ЦМГ	6,932,800.00	13,344,784.44
Хөрөнгө оруулалтын ЦМГ		
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	6,932,800.00	13,344,784.44
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		9,617,903.65
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		22,962,688.09
Төсвийн гүйцэтгэлийн тайлан ОНТ		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		624,634,888.04
Урсгал зардал		624,634,888.04
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
Орон нутгийн төсвөөс санхүүжих		607,549,525.00
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл		22,962,688.09

Гурав. Аудитын илрүүлэлт:

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 628.2 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад алдааг залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа:

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүү үр дүнгийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлогоос орлогыг 607.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.
- Бараа материалын тодруулга тайланд акталсан 6.1 сая төгрөгийн акталсан бараа материалыг зарцуулснаар зөрүүтэй тайлагнасан.
- Мөнгөн гүйлгээний тайлангийн зардлыг 14.2 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах," гэж заасныг зөрчсөн байна.
- Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 0.3 сая төгрөгийн гүйлгээ байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэж заасныг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 37.9 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 37.9 сая төгрөгийн 4 зөрчил² илэрч, зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

5.2 Албан шаардлага

1. Байгууллагын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөсөн зардлаас хангамж, бараа материалын зардлыг 29.5 сая төгрөгөөр, томилолтын зардал 4.0 сая төгрөгөөр, хэтрүүлэн зарцуулсан нь "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөг өөрчилсөн тухай бүрт тодотгосон төсөв хийж, хуулийн дагуу дахин зохих байгууллагаар төлөвлөгөө батлуулж, биелэлтийг хангах албан шаардлага хүргүүлсэн.

2. Аймгийн ИТХ-аас баталсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөний өөрийн орлогын төлөвлөвлөгөөг 4.3 сая төгрөгөөр тасалсан байна.

Шийдвэрлэсэн нь: Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан тухайд биелэлтийг заавал хангах албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Аймгийн ИТХ-аас төрийн албан хаагчдад орон нутгийн цалингийн нэмэгдэл олгох шийдвэр гаргасны дагуу 95.1 сая төгрөгийн цалингийн зарлага нэмэгдсэн байна. Байгууллагын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан эрх бүхий байгууллагаар шинэчлэн батлуулаагүй нь "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөг өөрчилсөн тухай бүрт тодотгосон төсөв хийж, хуулийн дагуу дахин зохих байгууллагаар төлөвлөгөө батлуулж, биелэлтийг хангах зөвлөмж хүргүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийтлэг үйлчилгээ УТҮГ	4	628.2	1	0.3	3	627.9	4	628.2	-	-	-	-

**Нийтлэг үйлчилгээ Улсын төсөвт үйлдвэрийн газрын 2023 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийтлэг үйлчилгээ УТҮГ	3	37.8	-	-	2	37.8	1	-	-	-	-	-

3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Нийтлэг үйлчилгээ УТҮГ	1	9.1	-	-	1	9.1	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТБОНӨА	1	1	-	-	-	1	-	-